



**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/906.

Улаанбаатар хот

Импорт, экспортын лиценз, тусгай
зөвшөөрлийн цаасан болон цахим архив үүсгэх
ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2022 оны А/189 дүгээр тушаалаар батлагдсан “Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Хөдөлмөрийн дотоод журам”-ын 2 дугаар зүйлийн 2.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эм, эмнэлгийн хэрэгслийн импорт, экспортын лиценз, тусгай зөвшөөрлийн 2021-2022 оны материалыг цаасан болон цахим архив үүсгэх “Ажлын хэсэг”-ийг нэгдүгээр, эм, эмнэлгийн хэрэгслийн импорт, экспортын лиценз, тусгай зөвшөөрлийн материалыг цаасан болон цахим архив үүсгэх ажлын хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд орсон архив үүсгэх ажлыг шуурхай хийж гүйцэтгэхтэй холбоотойгоор ажлын бус цагаар ажиллаж байгаа лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын албан хаагчдад хяналт тавьж ажиллахыг Агентлаг, хяналтын лабораторийн хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (Н.Уянга)-д үүрэг болгосугай.

3.Илүү цагаар ажилласан хөлсийг Хөдөлмөрийн тухай хууль болон зохих журмын дагуу тооцож олгохыг Санхүү, төсвийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (А.Болор-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газрын дотоод аудит, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэнд даалгасугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА

1422 01203

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2022 оны
...10 дугаар сарын 31-ны өдрийн 1/2022.6
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Л.Зэндмаа

Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын
дарга

Гишүүд:

О.Одончимэг

Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын
ахлах мэргэжилтэн

Б.Амарсанаа

Оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, тоног
төхөөрөмж, протезийн тусгай зөвшөөрлийн
асуудал хариуцсан мэргэжилтэн

Д.Бямбаа

Эм, биологийн идэвхит бүтээгдэхүүн ханган
нийлүүлэх, үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн
асуудал хариуцсан мэргэжилтэн

А.Номиндарь

Эмнэлгийн хэрэгсэл, мансууруулах, сэтгэцэд
нөлөөт эмийн импорт, экспортын лицензийн
асуудал хариуцсан мэргэжилтэн

Н.Галзул

Эмийн импортын лицензийн асуудал
хариуцсан мэргэжилтэн

--ooOOoo--

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2022 оны
...10... дугаар сарын 31...-ны өдрийн А/906.
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ИМПОРТ, ЭКСПОРТЫН
ЛИЦЕНЗ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН МАТЕРИАЛЫГ ЦААСАН БОЛОН
ЦАХИМ АРХИВ ҮҮСГЭХ АЖЛЫН ХУВААРЬ

д/д	Хариуцах албан тушаалтан	Ажиллах хугацаа	Ажиллах цагийн хувиар
1	О.Одончимэг	2022.10.31-12.25	Долоо хоног бүрийн лхагва, бямба
2	Б.Амарсанаа	2022.10.31-12.25	Долоо хоног бүрийн лхагва, бямба
3	Н.Галзул	2022.10.31-12.25	Долоо хоног бүрийн лхагва, бямба
4	А.Номиндарь	2022.10.31-12.25	Долоо хоног бүрийн бямба, ням
5	Б.Бямбаа	2022.10.31-12.25	Долоо хоног бүрийн мягмар, лхагва, ням

--ooOOoo--